

ТУШААЛЫН ТӨСӨЛ

2026 оны .. сарын .. өдөр

Журамд нэмэлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-146 дугаар тушаалаар баталсан Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журамд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/1 дүгээр зүйлийн 1.10, 1.11 дахь хэсэг:

“1.10.Энэхүү журмын дагуу үүсгэн байгуулах банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны 50-иас дээш хувийг гадаад улсын банк эзэмшдэг бол тус банк (цаашид “гадаадын банк” гэх)-д Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэг хамаарахгүй.

1.11.Зөвшөөрөл хүсэгч нь Монголбанканд ирүүлэх зөвшөөрлийн хүсэлтэд энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангах баримт бичиг, 3 дугаар зүйлд заасан өргөдөл, баримт бичгийг Монголбанкны Зөвшөөрлийн цахим системд оруулна.”

2/2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:

“2.3.Гадаадын банк үүсгэн байгуулахад дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

2.3.1.Монгол Улсад банк байгуулахыг банк үүсгэн байгуулагч банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн байх;

2.3.2.Банкны тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан банкны нэгдэлд авах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанк дангаар эсхүл банк үүсгэн байгуулагч банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.3.3.гадаадын банк нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасан хуулийн этгээд бол хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасны дагуу зөвшөөрсөн байх;

2.3.4.гадаадын банкны үүсгэн байгуулагч нь олон улсын аливаа хориг арга хэмжээний жагсаалтад ороогүй, эсхүл хориг арга хэмжээний жагсаалтад орсон улсад бүртгэлгүй байх;”

3/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь хэсэг:

“3.1.13.гадаадын банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй эсхүл ял шийтгэлийн хугацаа дууссаныг нотлох баримт бичиг;”

2.Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсгийн “өргөдөл гаргагчид” гэсний дараа “ажлын 5 хоногийн дотор”, 3.10 дахь хэсгийн “шаардаж болох бөгөөд” гэсний дараа “зөвхөн өргөдлийн бүрдүүлбэртэй холбоотойгоор” гэж тус тус нэмсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Банкны хяналт, шалгалтын газар (Ц.Дамдинсүрэн)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ